

2019 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хоршоог үүсгэн байгуулах, хоршооны удирдлага, зохион байгуулалт, хяналт, хоршоо болон гишүүнийн эрх, үүрэг, хоршооны үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршооны удирдах дээд байгууллага болон хоршооны талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоох, хоршоог өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хоршооны хууль тогтоомж

2.1. Хоршооны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай³ хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн хамрах хүрээ

3.1. Хадгаламж, зээлийн үйлчилгээг эрхэлж байгаа хоршооноос бусад хоршоо энэ хуулийг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Хоршоо" гэж эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, хоршооны хөрөнгөд үндэслэн үйл ажиллагаа явуулахаар иргэн, хуулийн этгээдийн хамтран байгуулсан хуулийн этгээдийг;

4.1.2. "Анхан шатны хоршоо" гэж эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, хоршооны хөрөнгөд үндэслэн үйл ажиллагаа явуулахаар 9 ба түүнээс дээш иргэний иргэн, хамтран байгуулсан хуулийн этгээдийг;

4.1.3. " Дундын хоршоо " гэж эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, хоршооны хөрөнгөд үндэслэн үйл ажиллагаа явуулахаар иргэн, хоршоо, хуулийн этгээд хамтран байгуулсан, 51-ээс доошгүй хувь нь хоршоо байх шаардлага хангасан хуулийн этгээдийг;

4.1.4. " Олон төрөлт үйл ажиллагаатай хоршоо" гэж энэ хуулийн 6.1-д заасан хэд хэдэн чиглэлээр үйл ажиллагаа нэгэн зэрэг эрхэлдэг хоршоог;

4.1.5. " Хөдөө аж ахуйн хоршоо " гэж эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, гишүүдийн дийлэнх олонх нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхэлдэг, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, хоршооны хөрөнгөд үндэслэн үйл ажиллагаа явуулахаар анхан болон дундын хоршооны хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдийг;

4.1.6. "Хоршооны гишүүн" гэж энэ хууль болон хоршооны дүрэмд заасан хэмжээгээр хоршоонд эдийн болон оюуны өмчөөр хувь нийлүүлсэн, оруулсан хөрөнгийн хэмжээнээс үл хамааран саналын нэг эрх бүхий иргэнийг, дундын хоршооны хувьд хоршоо, хуулийн этгээдийг;

4.1.7."Дэмжигч гишүүн" гэж хоршооны үйлчилгээг авч, түүний үйл ажиллагааг дэмжиж байгаа саналын эрхгүй этгээдийг;

4.1.8. "Гишүүний ажил, үйлчилгээ" гэж хоршооны гишүүн хоршоонд гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээг ;

4.1.9. "Хоршооны ажил үйлчилгээ" гэж хоршооны гишүүн болон нийгэмд чиглэсэн аливаа ажил, үйлчилгээг

4.1.10."гишүүний оюуны өмч" гэж хоршооны гишүүний хоршоондоо хувь нийлүүлэх байдлаар ашиглуулж буй өмчлөх эрх бүхий зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээл, эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг

4.1.11. "Хөрөнгө оруулагч "гэжашгийн бус хэлбэрээр хоршооны хөгжлийг дэмжих зорилгоор хоршоонд хувь нийлүүлэхээс бусад хэлбэрээр санхүүжилт, хөрөнгө оруулалт хийсэн хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.12. "Бараа" гэж хоршооны гишүүний бэлтгэсэн, түүхий эд, материал, үйлдвэрлэсэн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүнийг;

4.1.13. "Гишүүнд төлөх ёстой төлбөр" гэж хоршооны гишүүний барааг худалдан борлуулсан, оюуны өмчийг ашиглуулсны дараа гишүүнд төлөхөөр тохиролцсон гэрээний болон хэлцлийн үнийн дүнг;

4.1.14. "Борлуулалтын орлого" гэж гишүүдийн бараа, ажил, үйлчилгээ, оюуны өмчийг бусдад зуучлан борлуулсан, ашиглуулсан орлогоос гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлсний дараа хоршоонд үлдэх орлогыг;

4.1.15. "Нөөцийн сан" гэж хоршоонд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, энэ хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу хоршооны борлуулалтын орлогоос заавал хуримтлуулах мөнгөн хөрөнгийг;

4.1.16. "Хоршооны гишүүнд ногдох орлого" гэж энэ хуулийн 4.1.14-т тодорхойлсон хоршооны үлдэгдэл орлогоос бүх гишүүний хурлын шийдвэрээр гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгө, хөдөлмөр, оролцоо, ажил, үйлчилгээнд ногдох хэмжээгээр хуваарилах хөрөнгийг;

~~4.1.17. "Хоршооны үлдэгдэл орлого" гэж энэ хуулийн 4.1.13-т тодорхойлсон хоршооны борлуулалтын орлогоос энэ хуулийн 33,34 дугаар зүйлд заасан болон хоршооны дүрэмд заасан хувь хэмжээгээр нөөцийн сан болон хоршооны гишүүдэд хуваарилсны дараа хоршоонд үлдэх орлогыг;~~

4.1.18. "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэж нэг гишүүнээс энэ хуулийн 34.2 дугаар зүйлд заасан хэмжээгээр хоршоонд хувь нийлүүлэх энэ хуулийн 34.1-д заасан хөрөнгийг тус тус ойлгоно.

5 дугаар зүйл. Хоршооны үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Хоршоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана:

5.1.1. хууль дээдлэх

5.1.2. сайн дурын нээлттэй гишүүнчлэлтэй байх;

5.1.3. хараат бус, бие даасан байх;

5.1.4. гишүүдийн ардчилсан хяналтын доор хамтын шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулах;

5.1.5. гишүүдийнхээ эдийн засгийн оролцоогоор ажил хоршооны эд хөрөнгийг бүрдүүлэх;

5.1.6. үйл ажиллагааны тайлан нь гишүүдэд нээлттэй, ил тод байх;

5.1.7. гишүүдийн эдийн засаг, нийгэмийн асуудлыг шийдвэрлэх, хувь хүний хөгжлийг дэмжиж боловсрол олгох, давтан сургах, мэргэжил боловсролыг нь байнга дээшлүүлэх;

5.1.8. хууль болон дүрэмд заасан хоршооны гишүүний эрхийг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

5.1.9. хоршоод хоорондын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, хоршооллын хөгжлийг дэмжих.

6 дугаар зүйл. Хоршооны үйл ажиллагааны чиглэл

6.1. Хоршоо дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ:

6.1.1. хөдөө аж ахуй, газар тариалангийн;

6.1.2. үйлдвэрлэлийн;

6.1.3. худалдаа, хэрэглэгчдийн;

6.1.4. үйлчилгээний;

6.1.5. санхүүгийн үйлчилгээний;

6.1.6. хууль тогтоомжоор хориглоогүй дүрэмд заасан бусад үйл ажиллагаа.

6.2. Хадгаламж, зээлийн болон санхүүгийн үйлчилгээг дагнан эрхлэх хоршооны үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

6.3. Энэ хуулийн 6.1.1-6.1.4-т заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон төрөлт үйл ажиллагаатай хоршоо нь гишүүддээ санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд энэ хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл. Хоршооны үйл ажиллагаанд тавих шаардлага

7.1. Хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, гишүүдийнхээ хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг худалдан авч, зуучлан борлуулах үйлчилгээ эрхэлж байгаа бүх төрлийн хоршоо хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн байнгын бус оролцогч байна

7.2. 100- аас дээш гишүүнтэй хоршооны Тэргүүлэгчид нь захирлуудын зөвлөл болон хоршооны дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт тавих аудитын хороо, ёс зүй, эвлэрүүлэн зуучлах, маргаан таслах, зээлийн хороодыг байгуулж ажиллуулна. Зөвлөл, хорооны үйл ажиллагааг энэ хууль болон хоршооны дүрмээр зохицуулна.

7.3. Нэг тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой хоршоо гишүүддээ санал болгох хаалттай үнэт цаас гаргаж болно. Хаалттай үнэт цаас гаргахтай холбогдсон харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль³ болон хоршооны дүрмээр зохицуулна.

7.4. Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус оролцогчоор бүртгүүлж, эрх авсан хоршоо нь биржээр дамжуулан арилжаалах бараа, түүхий эдийг бэлтгэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэхтэй холбоотой асуудлыг бүрэн хариуцаж, цахим арилжаа хийх программ хангамж, технологийн нөхцөл шаардлагыг бүрэн хангана.

7.5. Хөдөө аж ахуй, газар тариалангийн хоршоо нь бэлчээрийн болон газар тариалангийн газар эзэмших эрхтэй. Эзэмшлийн газраа хоршооны гишүүн болон гишүүн бус иргэнд ашиглуулах асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

7.6. Хоршоо гишүүдийн бараа, түүхий эд, материалыг зуучлан борлуулахдаа гишүүнд ашигтай байх үнийг санал болгоно.

8 дугаар зүйл. Хоршооны хэлбэр

8.1. Хоршоо нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.

8.2. Хоршоо үүсгэн байгуулахад тавигдах шаардлагыг хангасан байдлаараа анхан шатны болон дундын, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээрээ олон төрөлт ба төрөлжсөн хэлбэртэй байна.

8.3. Хоршоо оршин байгаа засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийг хамарсан аймаг, нийслэл, бүс нутаг, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулах бол энэ хуулийн 8.2 дугаар зүйлд заасан хоршооны олон төрөлт ба дагнасан хэлбэрээр ажиллана.

8.4. Хоршоо нь үзүүлэх үйлчилгээний чиглэлээс хамаарч зөвхөн гишүүддээ үйлчлэх болон нийгэмд үйлчлэх хэлбэрээр ажиллаж болно.

8.5. Дундын хоршооны эрх зүйн байдлын зохицуулалт хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд энэ хуулийн хоршооны нийтлэг зохицуулалттай ижил байна.

8.6. Нийгэмд үйлчилдэг хоршоо нь Татварын тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХОРШООГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

9 дүгээр зүйл. Хоршооны гишүүдийн тоо

9.1. Анхан шатны хоршоог есөөс доошгүй иргэн үүсгэн байгуулна.

9.2. Хоршоо болон хуулийн этгээд хамтарч дундын хоршоо байгуулж болно. Дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байна.

9.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг хоршооны тоо 100-аас доошгүй байна.

10 дүгээр зүйл. Хоршоо хуулийн этгээд байгуулах

10.1. Хоршоо нь хоршооны үйл ажиллагааг дэмжих, гишүүддээ боловсрол олгох, давтан сургах, эрүүл мэндийн оношлогоо, үйлчилгээ үзүүлэх зорилгоор хууль тогтоомжийн дагуу сургалтын байгууллага болон эрүүл мэндийн төвийг байгуулж болно.

10.2. Хоршоо дангаар болон ижил төрлийн бусад хоршоотой хамтран энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээ эрхэлж болно.

10.3. Хоршоо нь хуулийн этгээд байгуулах асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

10.4. Энэ хуулийн 10.2-т заасан хуулийн этгээдийн хувьцаанаас нэг хоршооны эзэмших хувь хэмжээ нь тухайн хоршооны өөрийн хөрөнгийн 10 хувиас ихгүй байна.

11 дүгээр зүйл. Хоршооны салбар, төлөөлөгчийн газар

11.1. Хоршооны салбар, төлөөлөгчийн газрын эд хөрөнгийг хоршооны балансад тусгана.

11.2. Хоршооны салбар, төлөөлөгчийн газрын эд хөрөнгийн бүртгэл, үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврын хариуцлагыг Иргэний хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтын дагуу шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Хоршооны оноосон нэр, оршин байгаа газар

12.1. Хоршоо нь оноосон нэртэй байна. Хоршооны оноосон нэрийн ард "Хоршоо" гэсэн ялгах тэмдгийг хэрэглэнэ.

12.2. Хоршоог аль нэг гишүүний нэрээр нэрлэж үл болно.

13 дугаар зүйл. Үүсгэн байгуулах гэрээ

13.1. Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болох бөгөөд уг гэрээнд үүсгэн байгуулагчдын ажиллах журам, хүлээх үүрэг, хувь нийлүүлэх эд хөрөнгийн хэмжээ, хугацаа зэргийг тусгана.

13.2. Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болох ба хоршооны гишүүний эрх, үүрэг, хариуцлага, оруулсан хөрөнгийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хоршооны дүрмээр зохицуулна.

14 дүгээр зүйл. Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх

14.1. Хоршоо байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгүүлэхээр хуулиар шаардсан баримт бичгийг Улсын бүртгэлийн байгууллагад "Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль"-д заасан журмын дагуу хүргүүлж бүртгүүлнэ.

15 дугаар зүйл. Хоршооны дүрэм, түүний агуулга

15.1. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна.

15.2. Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батална.

15.3. Хоршооны дүрэмд дараахь асуудлыг тусгана:

15.3.1. хоршооны оноосон нэр, үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн нэр, хоршооны удирдлага байрладаг төв байрны байршин байгаа газрын хаяг

15.3.2. гишүүдийн ургийн овог, овог нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, гишүүн нь хоршоо, хуулийн этгээд бол тэдгээрийн оноосон нэр, үйл ажиллагаа явуулах засаг захиргааны нэгжийн нэр, төв байрны байршин байгаа газрын хаяг

15.3.3. хоршооны зорилго, хэлбэр, төрөл, үйл ажиллагааны чиглэл;

15.3.4. тодорхой хугацаагаар үйл ажиллагаа явуулахаар тохиролцсон бол үйл ажиллагаа явуулах хугацаа;

15.3.5. хоршооны гишүүнчлэл, гишүүн элсүүлэх журам, гишүүний татвар, гишүүний эрх, үүрэг, хариуцлага

15.3.6. гишүүний хувь нийлүүлэх хөрөнгийн хэлбэр, хэмжээ, гишүүнээс гарах, хасагдах үед оруулсан хөрөнгийн буцаан олгох, ногдол орлого хуваарилахтай холбоотой харилцаа

15.3.7. хоршооны болон дэмжигч гишүүний хөдөлмөр, оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийг үнэлэх арга

15.3.8. хоршооны орлого, үлдэгдэл орлого, ашиг тодорхойлох, бүртгэх аргачлал, үлдэгдэл орлогыг захиран зарцуулах, ногдол орлого хуваарилах, арга журам

15.3.9. хөрөнгө оруулагчаас хоршоонд хөрөнгө оруулалт татах болон хоршооны өөрийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх нөхцөл

15.3.10. хоршооны бүх гишүүдийн хурал, Төлөөлгчдийн болон Хяналтын зөвлөлийн хурал хуралдуулахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцаа

15.3.11. Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн гишүүн, даргыг сонгох, бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хоршооны дарга, эрх бүхий бусад албан тушаалтны жагсаалт, тэдгээрийг томилох журам, эрх үүрэг, шийдвэр гаргах, хариуцлага хүлээлгэх асуудал

15.3.12. Хоршооноос их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас үүссэн хохирлыг барагдуулах, үр дагаврыг арилгах журам

15.3.13. хоршооны салбар, төлөөлөгчийн газрын ажиллах үндэслэл, журам, түүний эрх, үүрэг, хариуцлага;

15.3.14. хоршооны үйл ажиллагаанд тавих дотоод болон аудитын хяналт

15.3.15. хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах ажиллагааг хэрэгжүүлэх, үлдэгдэл эд хөрөнгийг гишүүдэд хуваах, өр төлбөрийг барагдуулах журам

15.3.16. хоршооны мэргэжлийн холбоо, хоршооллын нэгдсэн холбоонд нэгдэх, холбооноос гарах

15.3.17. хоршоо, гишүүн, эрх бүхий албан тушаалтан, ажиллагсадын хооронд үүссэн аливаа маргааныг шийдвэрлэх журам, нөхцөл

15.3.18. хоршоо хаалттай үнэт цаас гаргах тохиолдолд гаргах үнэт цаасны хэмжээ, худалдах, худалдан авах, хоршооны хөрөнгөд хөрвөх, шилжүүлэх, бүртгэх журам

15.3.19. гишүүдийн заавал оруулах хувиас гадна хоршоонд нийлүүлж болох хувь хөрөнгийн дээд хэмжээ;

15.3.20. хоршооны орлого, зарлагыг тооцох, бүртгэх, түүнийг хуваарилах журам;

15.3.21. хоршооны тайлангийн жил;

15.3.22. аж ахуйн үйл ажиллагаандаа тухайн хоршооны гишүүн бус этгээд болон дэмжигч гишүүнийг оролцуулах нөхцөл, журам;

15.3.23. болзошгүй алдагдлыг нөхөх нөөцийн санг бүрдүүлэх арга, хэлбэр нөөцийн санд хуримтлуулах жилийн орлогын тодорхой хувь хэмжээ, түүнд байнга байлгах хөрөнгийн доод хэмжээ;

15 3.24. хариуцлага хүлээх журам, хязгаарлах хэсэг;

15.3.25. хоршооны эд хөрөнгө, түүнийг бүртгэх, ашиглах, захиран зарцуулах журам;

15.3.26. гишүүний хувь хөрөнгийг захиран зарцуулах, өв залгамжлах, бусдад шилжүүлэх журам;

15. 3.27. хоршооны үйл ажиллагаатай холбоотой зохицуулах шаардлагатай бусад зүйл

16 дүгээр зүйл. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

16.1. Хоршооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

16.2. Дүрэмд оруулах дараах нэмэлт, өөрчлөлтийг бүх гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ:

16.2.1. хоршооны үйл ажиллагааны хэлбэр, төрлийг өөрчлөх;

16.2.2. гишүүнээс хоршоонд хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

16.2.3. гишүүдийн нөхөх хариуцлагын хэмжээг өөрчлөх;

16.2.5. хоршооны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг тодорхой хэмжээгээр заавал хэрэглэж байхыг гишүүдэд үүрэг болгохтой холбоотой асуудал;

16.2.6. хоршоо бусад хоршоо, хуулийн этгээдэд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх

16.2.7. хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах

16.3. Хоршооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр гарснаас хойш 10 өдрийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

16.4. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа гишүүн 26.1-д заасны дагуу хоршооны гишүүнээс гарах эрхээ эдэлж болно.

17 дугаар зүйл. Хоршооны эрх, үүрэг

17.1. Хоршоо нь үйл ажиллагаагаа явуулахдаа дараахь эрх эдэлнэ:

17.1.1. хоршоог дэмжих талаар төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хамрагдаж, хоршоо хөгжүүлэх болон жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас олгох хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг авах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгийг авах;

17.1.2. өөрийн нэрийг ашиглах, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль³-ийн дагуу барааны тэмдэг, хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийг эзэмших онцгой эрх эдлэх, эдгээр эрхээ бусдад ашиглуулах, шилжүүлэх;

17.1.3. Иргэний хууль³-д заасан хуулийн этгээдийн эрх эдлэх, үүрэг хүлээх;

17.1.4. хоршооны дүрэмтэй байх, дүрмээ энэ хуульд заасны дагуу бүх гишүүдийн хурлаар батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

17.1.5. хууль, дүрэмд нийцсэн дотооддоо мөрдөх эрхийн акт батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;

17.1.6. энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө, оюуны өмч олж авах, эзэмших, ашиглах, өмчлөх, захиран зарцуулах /шилжүүлэх, худалдан авах, худалдах, түрээслэх, түрээслүүлэх, барьцаалах/;

17.1.7. Иргэний хууль³ болон энэ хуульд заасны дагуу хоршоог нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах;

17.1.8.энэ хуулийн дагуу хоршоо, хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, хоршооны мэргэжлийн холбоо, хоршооллын нэгдсэн холбоонд нэгдэн орох, гишүүн болох;

17.1.9.энэ хууль болон дүрэмд заасан нөхцөл болзлын дагуу хоршооны бие даасан байдалд сөргөөр нөлөөлөхгүй тохиолдолд Засгийн газар, байгууллага, иргэн, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагаас зээл, тусламж, төсвийн санхүүжилт, хандив авах;

~~17.1.10.энэ хуульд заасан нөхцлөөр эдийн засгийн гадаад харилцаанд оролцож, зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулах.~~

17.2. Хоршоо нь гишүүдийнхээ нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлж, амьдралын чанар, амьдрах орчинг сайжруулахад чиглэлээр дараахь үүрэг хүлээнэ

17.2.1. гишүүдийн хөдөлмөр, оролцоог үнэлж, хамтран хоршин ажиллах боломжийг бий болгох, гишүүдийн илүүдэл хөрөнгийн эх үүсвэрийг бүх гишүүний хурлаас тогтоосон хэмжээнд төвлөрүүлэн ашиглаж, үр ашигтай захиран зарцуулах замаар хуримтлал бий болгох, тогтоосон журмын дагуу зээл олгох;

17.2.2. гишүүний эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, экспорт, импортыг нэмэгдүүлэх, түүхий эд, материалаар хангах, хагас боловсруулалт хийх, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний зардал, өртгийг бууруулах, эрсдэлийг саармагжуулах замаар өгөөжийг нэмэгдүүлэх, гишүүдэд хуваарилах орлого, ашгийн хэмжээг нэмэгдүүлэх;

17.2.3. үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх техник, технологийг нэвтрүүлэх, хоршооны санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр энэ хуулиар зөвшөөрсөн эдийн засгийн гадаад харилцаанд оролцох;

17.2.4. гишүүдийг газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй болоход дэмжих, хоршооны эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгийг тэдгээрт ашиглуулах /давхар түрээслүүлэх, аж ахуйн зориулалтаар ашиглуулах/

17.2.5. бөөний болон жижиглэнгийн худалдааны төв, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн боловсруулалтын болон хагас боловсруулалтын жижиг дунд үйлдвэр, нийтийн зах байгуулах, тэдгээрийг өмчлөх, гишүүдээ ажиллуулах, гишүүнд түрээслэх;

17.2.6. түүхий эд, боловсруулсан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох, тэдгээрээр дамжуулан хоршооны үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэх, бизнесийн болон удирдлагын арга барил, туршлагыг гишүүдэд зааж сургах;

17.2.7. гишүүнчлэлийн нээлттэй зарчмыг удирдлага болгож, орлого багатай, амьдралын түвшин доогуур иргэдэд хоршооны үйл ажиллагаагаар дамжуулан гишүүнээр элсүүлэх, нийгэм, эдийн засгийн байдлаа дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

ьо

17.2.8. Засгийн газар болон бусад хоршоо, байгууллагуудтай хамтран ажиллах;

17.2.9. хоршооллын хөдөлгөөнийг дэмжих;

17.2.10. эдийн засгийн өсөлтөд нөлөөлж, ядуурлыг бууруулах зорилгоор өөртөө туслах, өөрөө ажлын байр¹ бий болгох явдлыг дэмжих;

17.2.11. энэ хуулиар хүлээлгэсэн бусад үүрэг.

18 дугаар зүйл. Хоршоонд хориглох зүйл

~~18.1. Хоршоо нь үйл ажиллагаагаа эрхлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих, худалдааны эрх чөлөөнд харшилсан мөнөөр төгтөөх, өрсөлдөөнийг хязгаарлах болон үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоохыг хориглоно.~~

18.2. Хоршооны эд хөрөнгийг зөвхөн хоршооны эрх ашигт нийцүүлэн ашиглах ба хувийн буюу өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Хоршооны үйл ажиллагаанд үл нөлөөлөх

19.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрч бусад аливаа этгээд хоршооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй бөгөөд удирдлага, шийдвэрт нь хууль бусаар нөлөөлөхийг хориглоно.

20 дугаар зүйл. Хоршооны хариуцлага

20.1. Хоршоо нь үйл ажиллагааны улмаас бий болсон үүргийг зөвхөн хоршооны хөрөнгөөр хариуцна.

20.2. Бүх гишүүний дийлэнх олонх хүлээн зөвшөөрснөөр зөвхөн дараах тохиолдолд хоршооны тухайн жилийн үлдэгдэл орлогоос гишүүнд ногдох орлогын дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр хоршооны өр төлбөрийн үүргийг гишүүн нөхөн төлнө:

20.2.1. Хоршоо нь өөрийн хөрөнгөөр бусад этгээдэд төлөх өр төлбөрөө барагдуулж чадахгүй болсон нь аудитын шалгалтаар тогтоогдсон;

20.2.2. тухайн жилийн үлдэгдэл орлогоос гишүүнд ногдох орлогын дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр хоршооны өр төлбөрийн үүргийг гишүүд нөхөн төлсөн тохиолдолд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах чадвартай болох нь аудитын дүгнэлтээр тогтоогдсон

21 дүгээр зүйл. Хоршооны гишүүн

21.1. Энэ хууль болон хоршооны дүрмийг хүлээн зөвшөөрч, хоршооны үйлчилгээг авах, хамтран ажиллаж, хариуцлага хүлээх чадвартай иргэн анхан шатны хоршоонд, хоршоо, хуулийн этгээд нь дундын хоршоонд сайн дураараа элсэнэ.

21.2. Хоршоонд гишүүн элсүүлэх асуудлыг энэ хууль болон хоршооны дүрмээр зохицуулна.

21.3. Хоршоо дэмжигч гишүүнтэй байж болно. Хоршооны дэмжигч гишүүний тоо, гишүүн элсүүлэх журмыг дүрэмд тусгана.

21.4. Хоёроос доошгүй жил хоршооны дэмжигч гишүүн, хөрөнгө оруулагч байсан этгээдийг түүний оролцоог үнэлж, хоршооны гишүүнээр элсүүлж болно.

21.5. Хоршоонд гишүүнээр элссэнээр гишүүн нь хоршооны эд хөрөнгийн зохих хувийн өмчлөгч болж, хоршооны гишүүний эрх, үүрэг үүснэ.

21.6. Нийлүүлсэн хувь хөрөнгийн үнийн нийт дүн нь хоршооны хөрөнгөнөөс гишүүнд оногдох хэмжээг тодорхойлно.

21.7. Хоршооны эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэмжээ нь гишүүний нийлүүлсэн нийт хувь хөрөнгө /заавал оруулах хувь хөрөнгө, илүү оруулсан хувь хөрөнгө, хөдөлмөр оролцоо/, тухайн гишүүнд ногдох хоршооны жилийн ашиг, алдагдлын зөрүүг тооцсон дүнтэй тэнцүү байна.

21.8. Гишүүдийн оруулах хувь хөрөнгө, хөдөлмөр оролцоо нь эд хөрөнгө, бэлэн мөнгө болон ажил, үйлчилгээ, оюуны өмчийн хэлбэртэй байна.

21.9. Хоршоонд гишүүний нийлүүлсэн нийт хувь хөрөнгийн хэмжээг үндэслэн хоршоо орлого хуваарилж болно.

21.10. Орлогын хуваарилалтыг Тэргүүлэгчид, Хяналтын Зөвлөлийн хамтарсан саналыг үндэслэн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

21.11. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хоршоо санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор орлого хуваарилах асуудлыг шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Хоршооны гишүүнээр элсүүлэх

22.1. Хоршооны гишүүнээр элсэхийг хүссэн этгээд нь хүсэлтээ хоршооны даргад гаргана. Хүсэлт гаргах журам, өргөдлийн маягтыг Тэргүүлэгчдийн хурлаар батална.

22.2. Хоршоонд гишүүнээр элсэхийг хүссэн иргэн хоршооны үйл ажиллагаа, удирдлага, менежмент, нягтлан бодох бүртгэлийн талаар тухайн салбарын мэргэжлийн холбооны сургалтад заавал хамрагдана.

22.3. Хоршооны гишүүнээр элсэх хүсэлтийг хоршооны дүрэмд өөрөө заагаагүй бол хоршооны бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

22.4. Гишүүнээр элсэх хүсэлтэд хоршооны бүх гишүүний хурал болон энэ хуульд заасан журмын дагуу төлөөлөгчдийн хурал татгалзсан хариу өгсөн тохиолдолд хүсэлт гаргагч татгалзсан үндэслэлийн талаар хуралд тайлбар хийх эрхтэй ба үүний дараа хурал дахин авч хэлэлцэх бөгөөд бүх гишүүдийн хурлын гаргасан хоёр дахь шийдвэр эцсийнх байна.

22.5. Хурлын шийдвэрийг үндэслэн хүсэлт гаргагч дүрэмд заасан хэмжээгээр гишүүний элсэлтийн татварыг төлж, хувь нийлүүлэх хөрөнгийг нийлүүлсний дараа гишүүний эрхийг баталгаажуулж, хоршооны Тэргүүлэгчдийн дарга түүнд гэрчилгээ олгоно.

22.6. Тэргүүлэгчид нь хоршоонд гишүүн элсүүлсэн тухай бүр холбогдох шийдвэрийг уг шийдвэр гарсанаас хойш 30 хоногийн дотор бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

22.7. Хоршоонд дэмжигч гишүүнээр элсэхийг хүссэн этгээд хүсэлтээ хоршооны даргад гаргана. Хоршооны дүрэмд заасан журмын дагуу хоршооны дарга хүсэлтийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

23 дугаар зүйл. Гишүүдийн бүртгэл хөтлөх

23.1. Хоршооны гишүүдийн бүртгэлийг Тэргүүлэгчдийн хурлаас томилогдсон бүртгэгч хөтөлнө.

23.2. Бүртгэлд дараахь асуудлыг тусгана:

23.2.1. гишүүний овог, нэр, оршин суугаа газрын хаяг, гишүүн хоршоо, хуулийн этгээдийн оноосон нэр, оршин байрлах газрын хаяг;

23.2.2. гишүүнээр элссэн, гишүүнээс гарсан, хасагдсан тухай;

23.2.3. хоршоонд гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө, төрөл, хэмжээ;

23.2.4. хоршооны орлого болон эд хөрөнгөөс тухайн гишүүнд хуваарилсан хэмжээ;

23.2.5. хоршооноос гаргасан үнэт цаас, бондоос эзэмшиж байгаа хэмжээ;

23.3. Хоршоо дэмжигч гишүүдийн бүртгэлийг хөтлөх ба бүртгэлийг Тэргүүлэгчдийн хурлаас тогтоосон журмын дагуу хөтөлнө.

24 дүгээр зүйл. Гишүүний бүртгэлтэй танилцах

24.1. Хоршооны гишүүн өөрийн бүртгэлтэй танилцах эрхтэй.

24.2. Хоршооны гишүүн хууль, дүрэмд заасан журмын дагуу бусад гишүүний бүртгэлтэй танилцаж болно.

24.3. Хоршооны гишүүний талаар мэдээлэл авсан этгээд нь уул мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

24.4. Мэдээлэл авсан этгээд түүнийг зөвхөн хоршооноос анх авсан шаардлагын дагуу ашиглана.

25 дугаар зүйл. Хоршооны гишүүний эрх, үүрэг

25.1. Хоршооны гишүүн дараахь эрхтэй:

25.1.1. хоршооны бүх гишүүний хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж, асуулт тавих, санал гаргах, оруулсан хөрөнгийн хэмжээнээс үл хамааран саналын нэг эрхтэй байх;

25.1.2. хоршооны үйл ажиллагаанд оролцож, Тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгох, сонгогдох, хоршооны дарга, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд өрсөлдөх, томилогдох;

25.1.3. хоршооны бүх гишүүний ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах санал гаргах;

25.1.4. энэ хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу хоршоогоор үйлчлүүлэх, түүхий эд, бараа бүтээгдэхүүнээ зуучлуулан борлуулах;

25.1.5. хоршооны санхүү, төлбөрийн байдал, удирдлага менежментийн талаар шаардлагатай мэдээллийг шаардан авах, мэдээллийг гишүүдэд ил тод, нээлттэй байлгахыг шаардах;

25.1.6. өөрийн хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийг үнэлүүлэх, үнэлэхийг шаардах;

25.1.7. хоршооны жилийн орлого, ашгаас энэ хууль болон хоршооны дүрэмд заасан журмын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгө, хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийн хэмжээнд ногдол хувь хүртэх;

25.1.8. хоршооны жилийн санхүүгийн тайлантай танилцах, шаардлагатай гэж үзвэл бүх гишүүний хурлаар уг тайланг хэлэлцэн батлахаас өмнө Хяналтын зөвлөлөөс тайлангийн талаар дүгнэлт гаргахыг шаардах, гаргуулан авах;

25.1.9. хоршооны бүх гишүүдийн хурлын тэмдэглэлтэй танилцах;

25.1.10. хоршооны гишүүдийн бүртгэлтэй танилцах;

25.1.11. энэ хууль, дүрмээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг хоршооны удирдлага, эрх бүхий албан тушаалтнаас шаардах;

25.1.12. өөрийн хүсэлтээр гишүүнээс гарах, дахин элсэх;

25.1.13. хоршоог татан буулгасны дараа үлдэх хөрөнгө болон тэдгээрийг борлуулсаны орлогоос хувь хүртэх;

25.1.14. хууль, дүрэмд өөрөөр заагаагүй бол ижил төрлийн дагнасан үйл ажиллагаа эрхэлдэггүй, өрсөлдөгч бус өөр хоршоонд гишүүн байх, хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч байх;

25.1.15. малчин гэр бүлийн нэг гишүүн гэр бүлийн бусад гишүүний бичгээр олгосон итгэмжлэлээр түүнийг төлөөлөн бүх гишүүний хуралд саналын эрхтэй оролцох;

25.1.16. хоршооны гишүүний урамшуулалд хамрагдах, хөнгөлөлт эдлэх, гишүүний урамшууллын карт эзэмших;

25.1.16. хууль, дүрэмд заасан бусад эрх;

25.2. Хоршооны гишүүн дараахь үүрэгтэй:

25.2.1. хоршооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцох, хоршооны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг заавал авах, үзүүлэх, түүхий эд, материал, бараа бүтээгдэхүүнээ түүнд нийлүүлэх, хоршоогоор зуучлуулан борлуулах;

25.2.2. хоршооны тухай хууль, хоршооны дүрэм, бүх гишүүний хурлын шийдвэрийг дагаж мөрдөх, хоршоонд оруулах хувь хөрөнгө, гишүүний элсэлтийн

татварыг тогтоосон хугацаанд төлөх, хоршооноос зээлсэн, ашигласан эд хөрөнгөтэй холбоотой үүссэн үүргийг хугацаанд нь гүйцэтгэж байх;

25.2.3. хоршооны бусад гишүүний өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, өр төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах;

25.2.4. ижил төрлийн дагнасан үйл ажиллагаа эрхэлдэггүй, өрсөлдөгч бус өөр хоршоонд гишүүн, хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч болсон тохиолдолд энэ тухай хоршоонд нэн даруй мэдэгдэх, зөвхөн нэг хоршоонд сонгогдох эрхтэй байх;

~~25.2.5. хөдөө аж ахуйн хоршооны гишүүн өөрийн үйлдвэрлэдэг гол нэрийн бүтээгдэхүүнээ хоршоотой хамтран борлуулж, хоршоогоо дэмжиж ажиллах~~

25.2.6. бүх гишүүдийн хуралд заавал оролцох;

25.2.6. хууль, дүрэмд заасан бусад үүрэг.

26 дугаар зүйл. Хоршооны гишүүний бүрэн эрх дуусгавар болох

26.1. Хоршооны гишүүн хоршооноос гарсан, түүнийг хоршооны гишүүнээс хассан тохиолдолд бүрэн эрх дуусгавар болно.

26.2. Хоршооны гишүүн дараахь тохиолдолд гишүүнээс гарна:

26.2.1. хоршооны гишүүн хоршооны гишүүнээс гарах хүсэлт гаргасан;

26.2.2. гишүүн нь хоршооны оршин буй газраас өөр нутаг дэвсгэрт шилжсэнээр хоршооны үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон;

26.2.3. гишүүн хоршоонд оруулсан хувь хөрөнгөө бусдад бүхэлд нь шилжүүлсэн;

26.2.4. хоршооны гишүүн нас барсан, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарласан;

26.2.5. гишүүнийг сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй болсныг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

26.3. Энэ хуулийн 26.2.1, 26.1.2-т заасан үндэслэлээр хоршооноос гарах тохиолдолд гишүүн хоршооноос гарах хүсэлтээ хоршооны санхүүгийн жил дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө бичгээр гаргана.

26.4. Гишүүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй болсныг тогтоосон бол түүний өв залгамжлагч, эсхүл хоршооны гишүүний бүртгэл хариуцсан ажилтан, сонирхогч этгээд тухайн этгээдийг гишүүнээс гарах хүсэлтийг хоршооны Тэргүүлэгчдэд нэн даруй гаргана.

26.5. Нас барсан, сураггүй алга болсонд тооцсон, нас барсан гэж зарлагдсан гишүүний хоршоонд оруулсан хувь хөрөнгийг өвлөхтэй холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

26.6. Нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан гишүүний өв залгамжлагч өөрөө хүсвэл хоршооны гишүүнээр элсч болно. Энэ тохиолдолд түүний хүсэлтийг хоршоонд шинээр гишүүн элсүүлэх журмын дагуу шийдвэрлэнэ.

26.7. Хоршооны гишүүнээс дараахь үндэслэлээр хасч болно:

26.7.1. хоршооны гишүүн хууль, дүрэмд заасан үүргээ зөрчсөн;

26.7.2. энэ хуулийн 26.7.1-д заасан үндэслэлээр хоршооны гишүүнээс хасах тухай Тэргүүлэгчдийн сануулга авсны дараа уг зөрчлийг дахин гаргасан;

26.7.3. хоршооны дүрмээр тогтоосон хугацаанд хоршооны үйлчилгээг аливаа хэлбэрээр ашиглаагүй;

26.7.4. тухайн хоршоотой өрсөлдөх хоршоог өөрөө байгуулсан, эсхүл өрсөлдөгч хоршоонд хувь хөрөнгө нийлүүлсэн буюу түүнээс хувь хөрөнгө авч уг хоршоонд нийлүүлсэн;

26.7.5. хоршооны хөгжил, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх, хохирол учруулах үйлдэл, эс үйлдэл хийсэн;

26.7.6. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 ба түүнээс дээш удаа бүх гишүүдийн хуралд оролцоогүй;

26.7.7. энэ хуульд нийцүүлэн хоршооны дүрмээр тогтоосон бусад үндэслэл.

26.8. Энэ хуулийн 26.7-т заасан үндэслэл бий болсон тохиолдолд хоршооны Тэргүүлэгчид энэ тухай хоршооны гишүүнд бичгээр урьдчилан мэдэгдэж, тайлбар хийх боломж олгоно.

26.9. Хоршооны гишүүн нь гишүүнээс хасах үндэслэлийг эс зөвшөөрч байвал мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүх гишүүдийн хурал хуралдуулах, түүнд тайлбар хийх нөхцөл бүрдүүлэхийг шаардах эрхтэй.

26.10. Хоршооны гишүүнээс хасах, гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох асуудлыг дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ. Бүх гишүүдийн хурлын шийдвэр эцсийнх байна.

26.11. Хоршооны гишүүнээс хасах тухай шийдвэрт хасах болсон үндэслэл, шалтгааныг тодорхой тусгана.

26.12. Хоршооны гишүүнээс гарсан болон хассан тухай шийдвэр гарснаар уг гишүүний бүрэн эрх дуусгавар болно.

26.13. Хоршооны гишүүнээс хассан тухай шийдвэрийг тухайн этгээд эс зөвшөөрвөл гомдлоо 14 хоногийн дотор хоршооны Хяналтын зөвлөлд гаргаж болно.

26.14. Хяналтын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн этгээд зохих журмын дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

27 дугаар зүйл. Хоршооны гишүүнээс гарсны үр дагавар

27.1. Энэ хуулийн 26.1-д заасны дагуу хоршооны гишүүнээс гарсан иргэн, хуулийн этгээдэд хоршоонд нийлүүлсэн хувь хөрөнгийг нь эргүүлэн олгоно. Хувь нийлүүлсэн хөрөнгө, хөдөлмөр оролцоо, оюуны өмч, ажил үйлчилгээнд нь ногдох орлогыг олгох тухай асуудлыг хоршооны дүрэмд заасан журмын дагуу бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

27.2. Энэ хуулийн 26.2-д заасан нөхцлөөр гишүүн хоршооны гишүүнээс гарсанд тооцогдсон тохиолдолд өв залгамжлагч, эцэг эх, асран хамгаалагч нь энэ хуулиар тогтоосон хоршооны гишүүнчлэлийн болзлыг хүлээн зөвшөөрвөл гишүүнчлэлийг үргэлжлүүлэн хадгалж болно.

28 дугаар зүйл. Хоршооны гишүүнээс хасагдсан этгээдийн тооцоог хийх

28.1. Хоршооны гишүүнээс хасагдсан этгээд хоршоонд аливаа хохирол учруулаагүй бол хоршооны эд хөрөнгөд нийлүүлсэн хөрөнгөө буцаан авах эрхтэй буюу өөр гишүүнд шилжүүлж болно.

28.2. Гишүүнээс хасагдсан иргэн, хуулийн этгээдийн хоршоонд хувь нийлүүлсэн хөрөнгөөс түүний хоршоонд учруулсан хохирлыг суутган тооцож, үлдэх хэсгийг олгоно. Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох орлого хуваарилах тухай асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

28.3. Хоршооны өр төлбөр дээр тухайн гишүүний оруулсан хувь хөрөнгөд ногдох өр төлбөрийг нэмсэн нийлбэр дүнгээс хоршооны эд хөрөнгийн дүн бага байвал энэ зүйлийн 28.1-т заасан ногдох орлогыг хоршооны гишүүнээс хасагдсан иргэн, хуулийн этгээдэд буцаан олгохгүй.

28.4. Гишүүнээс хасагдсан иргэн, хуулийн этгээдийн хоршоонд учруулсан хохирлыг Иргэний хууль³ болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд нөхөн төлүүлнэ.

28.5. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хоршооны гишүүнээс гарсан, хасагдсан этгээдийн хувь нийлүүлсэн эд хөрөнгийг улирлын тайланд үндэслэн буцаан олгох ба хөдөлмөр, оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчид ногдох орлогын тооцоог санхүүгийн жилийн эцсийн тайланг үндэслэн дараа жилийн эхний улиралд хийнэ.

29 дүгээр зүйл. Хувь нийлүүлсэн хөрөнгөө бусдад шилжүүлэх

29.1. Хоршооны гишүүн хоршоонд нийлүүлсэн өөрийн хувь хөрөнгийг бичгээр хийсэн гэрээний дагуу өөр гишүүнд хэдийд ч шилжүүлж болно.

29.2. Хувь хөрөнгөө бусдад шилжүүлэх шийдвэр гаргасан хоршооны гишүүн хувь хөрөнгийг шилжүүлэн авах давуу эрхийг хоршооны бусад гишүүнд эхний ээлжинд олгоно.

29.3. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу гишүүний хувь хөрөнгийг шилжүүлэн авсан этгээдийн шилжүүлэн авсан болон өөрийнх нь нийлүүлсэн хувь хөрөнгийн нийт хэмжээ хоршоонд нэг гишүүний хувь нийлүүлэх дүрмээр тогтоосон дээд хязгаараас илүүгүй байна.

30 дугаар зүйл. Гишүүний эд хөрөнгийн эрх өв залгамжлагчид шилжих

30.1.Хоршооны гишүүн нас барсан бол гишүүний эд хөрөнгийн эрх Иргэний хуульд заасны дагуу түүний өв залгамжлагчид шилжинэ.

30.2.Өв залгамжлагч нь хоёр ба түүнээс дээш байвал гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд өв залгамжлагчид саналын нэг эрхтэй байна.

~~30.3.Өв залгамжлагчийг гишүүнээр элсүүлэх асуудлыг бүх гишүүний хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.~~

30.4. Өв залгамжлагч нас барсан гишүүнтэй адил эрхтэй байна.

30.5. Хоёр ба түүнээс дээш өв залгамжлагч хоршоонд гишүүнээр элсэх бол ердийн журмаар шийдвэрлэнэ.

31 дүгээр зүйл. Хоршооны хөрөнгө

31.1. Хоршооны хөрөнгө нь хоршооны гишүүдээс хувь нийлүүлсэн хөрөнгө /хоршоологчдын өмч/ болон хоршооны өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

31.2. Хоршооны өөрийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

31.2.1. дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар;

31.2.2. хоршоонд бусдаас бэлэглэсэн, хандивласан болон буцалтгүй тусламжийн хэлбэрээр өгсөн тусламжийн хөрөнгө, төсвийн санхүүжилт;

31.2.3. хоршооны үлдэгдэл орлогоос нөөцийн санд хуваарилсан хөрөнгө;

31.2.4. хоршооны үлдэгдэл орлогоос тусгай зориулалтын бусад санд хуваарилсан хөрөнгө;

31.2.5. хоршооны өмчлөл дэх газар, үл хөдлөх, хөдлөх болон биет бус бусад эд хөрөнгө, оюуны өмч.

31.3. Хоршоо татан буугдаж, үйл ажиллагаа нь дуусгавар болсон үед хоршооны өөрийн хөрөнгөнөөс бусдад төлөх өр төлбөрийг нэн даруй барагдуулна. Үүний дараа үлдсэн хөрөнгийг хоршоонд хувь нийлүүлсэн хөрөнгөнд нь ногдох хэмжээгээр тооцож гишүүнд хуваарилна.

31.4. Гишүүн хоршооноос гарсан, хасагдсан тохиолдолд хоршоонд бэлэглэсэн, хандивласан хөрөнгөнөөс гишүүнд хуваарилахгүй.

32 дугаар зүйл.Хоршооны хөрөнгийг бүртгэх

32.1. Хоршооны хөрөнгийг энэ хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль³, , хоршооны дүрэм, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын дагуу бүртгэнэ.

32.2. Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн эд хөрөнгө, хоршооны үлдэгдэл орлогоос гишүүнд хуваарилсан ногдол орлогыг хоршооны гишүүний нэр дээр давхар бүртгэнэ.

32.3. Хоршооны гишүүний хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг үнийн дүнгээр, биет ба биет бус хөрөнгийг хөрөнгийн нэрээр данс нээж бүртгэнэ. Биет ба биет бус хөрөнгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу үнэлнэ.

32.4. Гишүүдийн хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийн үр шимийг үнэлэх журмыг эрх бүхий этгээдээс баталсан аргачлалын дагуу бүх гишүүдийн хурал батлах ба тогтоосон үнэлгээг үндэслэн тухайн гишүүний нэр дээр бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгана.

32.5. Хоршооны үлдэгдэл орлогоос гишүүнд хуваарилсан хувийг дүрэмд заасан журмын дагуу бүртгэнэ.

32.6. Хоршооны хөрөнгө нь хоршооны нэр дээр бүртгэгдэнэ.

32.7. Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага баталж мөрдүүлнэ.

32.8. Хоршооны санхүүгийн жил хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ий өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ий өдөр дуусгавар болно.

33 дугаар зүйл. Хоршоонд гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгө

33.1. Хоршооны гишүүн хоршоонд эд хөрөнгө, мөнгөн хөрөнгө, хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчөөр хувь нийлүүлж болно.

33.2. Хоршоонд нэг гишүүний хувь нийлүүлэх хөрөнгийн дээд хэмжээ хоршооны хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. Энэ хэмжээ нь 100-аас доош гишүүнтэй хоршоонд хамаарахгүй.

33.3. Хоршооны гишүүнээс хоршоонд хувь нийлүүлэх хөрөнгийн хэлбэр, хэмжээг энэ хуулиар тогтоосон дээд хэмжээнээс хэтрүүлэлгүйгээр хоршооны дүрмээр тогтооно. Хоршоонд гишүүний хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээг өөрчлөх тухай бүр хоршооны дүрэмд өөрчлөлт оруулна.

33.4. Гишүүний хоршоонд хувь хөрөнгө нийлүүлснийг гэрчилж, гэрчилгээ олгоно. Гэрчилгээ олгох журмыг хоршооны дүрмээр тогтооно.

33.5. Хоршооны эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэмжээ нь гишүүний нийлүүлсэн нийт хувь хөрөнгө /заавал оруулах хувь хөрөнгө, илүү оруулсан хувь хөрөнгө, хөдөлмөр оролцоо/, тухайн гишүүнд ногдох хоршооны жилийн ашиг, алдагдлын зөрүүг тооцсон дүнтэй тэнцүү байна.

34 дүгээр зүйл. Хоршооны үлдэгдэл орлогоос нөөц санд хөрөнгө хуваарилах

34.1. Бүх гишүүний хурлын шийдвэрээр хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг хоршоонд учирч болзошгүй алдагдлыг нөхөх зорилгоор нөөц санд хуваарилж зардалд тусгана. Нөөцийн сангаас өмнөх

жилийн алдагдлыг нөхнө. Нөөцийн сан нь алдагдлыг нөхөж хүрэлцэхгүй тохиолдолд нөөцийн санд хуваарилах хөрөнгийн хувь хэмжээг бүх гишүүдийн хурлаар нэмэгдүүлж тогтоож болно.

34.2. Нөөцийн сангийн хөрөнгийг зөвхөн хоршооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, алдагдлыг нөхөх, эрсдлийг бууруулахад ашиглана.

34.3. Хоршооны дүрмээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд нөөцийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад зориулан ашиглахгүй.

35 дугаар зүйл. Хоршооны гишүүнд ногдох орлого хуваарилах

35.1. Энэ хуулийн 34.1-д заасны дагуу нөөцийн санд хуваарилсны дараа хоршоонд үлдэх орлогоос дүрэмд заасны дагуу гишүүдийн оруулсан хувь хэмжээгээр /хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийн үр шимд / ногдох орлогыг хуваарилна.

35.2. Гишүүн тус бүрд ногдох орлогын хэмжээг энэ хууль болон дүрэмд заасны дагуу хийсэн үнэлгээ, хоршооны Тэргүүлэгчид болон Хяналтын Зөвлөлөөс хамтран оруулсан саналыг харгалзан бүх гишүүний хурал тогтооно.

35.3. Хоршооны гишүүн хоршооны өмнө хүлээсэн хугацаа хэтэрсэн өр төлбөртэй тохиолдолд түүнд ногдох орлогоос хугацаа хэтэрсэн өр төлбөрийг хасч, үлдэх дүнгээр хуваарилна.

36 дугаар зүйл. Цэвэр үлдэгдэл орлого тодорхойлох

36.1. Хоршоо дараа оны эхний улиралд багтаан /санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор/ үлдэгдэл орлогыг тодорхойлно. Хоршооны үлдэгдэл орлогоос татвар төлсний дараа үлдэх орлого нь хоршооны цэвэр үлдэгдэл орлого байна.

37 дугаар зүйл. Хоршооны цэвэр үлдэгдэл орлогоос хөгжлийн болон бусад санд хөрөнгө төвлөрүүлэх

37.1. Хоршооны цэвэр үлдэгдэл орлогыг бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хоршооны цаашдын хөгжил, гишүүдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах санд төвлөрүүлж болно.

37.2. Сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг хоршооны бүх гишүүний хурлаар батална.

38 дугаар зүйл. Хоршоонд хөрөнгө оруулах

38.1. Хоршоо нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор хоршооны гишүүн бус этгээдээс хөрөнгө оруулалт, санхүүжилт авах буюу хаалттай үнэт цаас гаргаж болно. Хоршоонд хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгийн хэмжээ хоршооны өөрийн хөрөнгийн 34 хувиас хэтрэхгүй байна.

38.2. Хөрөнгө оруулалтын нөхцлийг хоршоо, хөрөнгө оруулагч хоёрын хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна.

38.3. Хөрөнгө оруулагч нь хоршооны удирдлага, үйл ажиллагаанд оролцохгүй ба хоршооны эрх барих дээд байгууллагын хуралд оролцох, санал өгөх, сонгох, сонгогдох, ногдол орлого авах зэрэг гишүүний аливаа эрх эдлэхгүй.

39 дүгээр зүйл. Хоршооноос хөрөнгө оруулалт хийх

39.1. Хоршооны хөгжлийн сангаас дараахь зүйлд хөрөнгө оруулалт хийж болно:

39.1.1. хуулиар зөвшөөрсөн хуулийн этгээд /хоршоо, даатгал, санхүүгийн байгууллага, банкны /-ийн энгийн хувьцаа эзэмших;

39.1.2. мэргэжлийн байгууллагаар зуучлуулж, Засгийн газраас гаргасан эсвэл түүний баталгаажуулсан бонд, үнэт цаас худалдах авах;

39.1.3. хоршооны нэр дээр хоршоо болон гишүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах.

39.2. Хоршооноос нэг этгээдэд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ түүний өөрийн хөрөнгийн 20 хувиас дээшгүй хэмжээтэй байна.

39.3. Хоршооноос хөрөнгө оруулалт хийх хэмжээ, журмыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталсан байна

39.4. Үнэт цаас гаргах, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх журмыг бүх гишүүдийн хурлаар батална.

ГУРАВДУГААРБҮЛЭГ

ХОРШООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

40 дүгээр зүйл. Хоршооны эрх барих байгууллага

40.1. Хоршооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт түүний бүрэн эрхийг тэргүүлэгчид хэрэгжүүлнэ. Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны хэлбэр нь тэргүүлэгчдийн хуралдаан байна.

40.2. Хоршоо нь хоршооны гишүүдээс сонгогдсон Тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн дарга, Хяналтын зөвлөлтэй байна.

41 дүгээр зүйл. Бүх гишүүний хурал

41.1. Хоршооны бүх гишүүний хурлыг гишүүдээс сонгогдсон хурлын Тэргүүлэгчид удирдана. Бүх гишүүний хурал хуралдуулахтай холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг хоршооны дүрмээр зохицуулна.

41.2. Гишүүд хоршоонд холбогдох асуудлыг шийдвэрлэх эрхээ бүх гишүүний хурлаар дамжуулан хэрэгжүүлнэ.

41.3. Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

41.4. Дор дурдсан асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ:

41.4.1. дүрэмд батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

41.4.2. энэ хуулийн -45 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хоршоонд гишүүн элсүүлэх;

41.4.3.Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх, огцруулах, тэдгээрийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөлийн гишүүнийг хоршооны гишүүнээс хасах;

41.4.4.Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөлийн гишүүний хууль бус үйл ажиллагааны улмаас хоршоонд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;

41.4.5. хоршооны эд хөрөнгийг захиран зарцуулах нөхцөл журам тогтоох, тухайн жилийн төсөв батлах;

41.4.6. гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгийг буцааж олгох, зээл авах болон зээл олгох хязгаарлалтыг тогтоох;

41.4.7. хоршооны гишүүний элсэлтийн татварын хэмжээг тогтоох;

41.4.8. хоршоонд хөрөнгө оруулалт татах, хоршооноос хөрөнгө оруулалт хийх нөхцөл,журам батлах;

41.4.9. үнэт цаас гаргах, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх журам батлах;

41.4.10. хоршооны хөгжлийн болон бусад сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам батлах;

41.4.11. гишүүний хөдөлмөр оролцоо, ажил үйлчилгээ, оюуны өмчийн үр шимийг үнэлэх аргачлал батлах;

41.4.12. тайлан, тэнцлийг батлах, тухайн жилийн орлогыг хуваарилах, алдагдалтай ажилласан бол хэрхэн нөхөх, хоршоодын холбоо болон Хяналтын зөвлөлийн шалгалтын дүнг хэлэлцэх, зардлын төсөв батлах;

41.4.13. дундын хоршоо байгуулах буюу түүнд элсэх, хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэх;

41.4.14. хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

41.4.15. Хоршооны дарга, Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;

41.4.16. хуульд заасан бусад асуудал.

41.5. Бүх гишүүний хурал олонх оролцооноор хүчин төгөлдөр болно.

41.6. Бүх гишүүний хурлын шийдвэрийг хуульд өөрөөр заагаагүй бол санал хураалтад оролцсон гишүүний олонхын саналаар гаргана. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа хоршооны гишүүний хурлын шийдвэрийг ердийн олонхын саналаар гаргана.

41.7. Нийлүүлсэн хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамааран бүх гишүүдийн хуралд гишүүн тус бүр нэг саналын эрх эдэлнэ. Малчин гэр бүлийн гишүүн гэр бүлийн бусад гишүүний бичгээр олгосон итгэмжлэлээр саналын эрхийг нь эдэлж болно.

41.8. Хуралд хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хүндэтгэх шалтгаантайгаар оролцож чадаагүй гишүүдээс бусад бүх гишүүн хуралд оролцож байгаа тохиолдолд тэдний дийлэнх олонхын зөвшөөрснөөр хэлэлцэж болно.

41.9. Хоршооны гишүүн бүх гишүүний хуралд биечлэн оролцож саналаа өгнө.

41.10. Хуралд биечлэн оролцох боломжгүй болсон гишүүн итгэмжлэл бүхий хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан энэ хуулийн 25.1-д заасан эрхээ хэрэгжүүлнэ.

41.11. Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, Тэргүүлэгчдийн даргыг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн ажиллах журам, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох тухай асуудлыг бүх гишүүний хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

42 дугаар зүйл. Бүх гишүүдийн хурал зарлан хуралдуулах журам

42.1. Тэргүүлэгчид, хоршооны дарга бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулна. Тэргүүлэгчид байхгүй тохиолдолд бүх гишүүний гуравны нэгээс доошгүй хувийн саналаар ээлжит ба ээлжит бус хурлыг зарлана.

42.2. Тэргүүлэгчид бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулахгүй бол бүх гишүүдийн хурлыг Хяналтын зөвлөл зарлан хуралдуулна.

42.3. Хоршооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувийн саналаар дараахь тохиолдолд бүх гишүүний ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

42.3.1. Энэ хуулийн 42.2, 42.5-д заасан шаардлагыг биелүүлээгүй Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн гишүүнийг өөрчлөх эсэх асуудлыг хэлэлцэх;

42.3.2. хоршоонд их хэмжээний хохирол учруулсан Тэргүүлэгч, Хяналтын зөвлөлийн гишүүнийг огцруулж, хоршооноос хасах болон хоршооны гишүүнийг хоршооноос гаргах, хасах, түүнд хохирлыг нөхөн төлүүлэх хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шаардлагатай болсон;

42.3.3. хоршооны дарга, Тэргүүлэгч, Хяналтын зөвлөлийн гишүүн, төлөөлөгч хоршооноос гарсантай холбоотойгоор нөхөн сонгох асуудлыг хэлэлцэх;

42.3.4. жилийн болон завсрын тайланг гаргах үед эсхүл баримжаалж тооцсон алдагдлыг хоршооны нийт хөрөнгийн дүнгийн 50 хувь болон нөөцийн сангийн хөрөнгөөр нөхөж чадахгүйд хүрсэн нөхцөл бий болсон;

42.3.5. хоршооны үйл ажиллагаатай холбоотой хойшлуулшгүй нөхцөл бий болсон.

42.4. Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах тухай саналаа гишүүд бичгээр гаргаж гарын үсгээ зурах ба түүнд бүх гишүүдийн хурлыг хуралдуулах үндэслэл, шалтгааныг заана.

42.5. Энэ хуулийн 42.3-т заасан тохиолдолд Тэргүүлэгчид бүх гишүүдийн хурал хуралдуулах үндэслэл, шалтгаан, хэлэлцэх асуудлын талаар гишүүдэд мэдэгдэнэ.

42.6. Энэ хуулийн 42.2, 42.5-д заасан шаардлагыг биелүүлээгүй Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн гишүүдийг өөрчлөх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр бүх гишүүдийн хурлыг нэн даруй зарлан хуралдуулна

43 дугаар зүйл. Бүх гишүүний хурал хуралдах хугацаа, газар

43.1. Бүх гишүүний ээлжит хурлыг тайлангийн жил дууссанаас хойш 6 сарын дотор хийнэ.

43.2. Шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

43.3. Бүх гишүүний хурлыг өөр газар хуралдуулахаар товлоогүй бол хоршооны төв оршин байгаа газар хуралдуулна.

44 дүгээр зүйл. Бүх гишүүдийн хурал зарлах хэлбэр

44.1. Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлыг 30-аас доошгүй хоногийн өмнө зарлана.

44.2. Бүх гишүүдийн хурлыг бэлтгэн явуулах ажлыг Тэргүүлэгчид эрхлэн гүйцэтгэнэ. Тэргүүлэгчидгүй тохиолдолд Хоршооны дарга, гүйцэтгэх удирдлага зохион байгуулна.

44.3. Шийдвэр гаргахгүйгээр хэлэлцэх, мэдээлэх асуудлыг бүх гишүүдийн хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө төлөвлөгөөнд оруулан хэлэлцэж болно.

44.4. Энэ хуулийн 44.3 дахь заалт нь хурал удирдах, бүх гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулахтай холбогдсон асуудлаар шийдвэр гаргахад үл хамаарна.

45 дугаар зүйл. Төлөөлөгчдийн хурал

45.1. 100-аас дээш тооны гишүүнтэй анхан шатны хоршоо шаардлагатай гэж үзвэл бүх гишүүний хурлын оронд төлөөлөгчдийн хуралтай байж болно.

45.2. Төлөөлөгчдийн хурал нь энэ хууль, хоршооны дүрмээр олгосон бүрэн эрхээ тухайн төлөөлөгчдийг сонгосон бүх гишүүний хурлаас дараачийн төлөөлөгчдийг сонгох бүх гишүүдийн хурал хүртэлхи хугацаанд хэрэгжүүлнэ.

45.3. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчдийн хуралд энэ хуулийн 41.4.1, 41.4.5, 41.4.10-аас бусад бүх гишүүдийн хуралд хамаарах заалт нэгэн адил хамаарна.

45.4. Төлөөлөгчдийн хурлын гишүүний тоо, түүний бүрэн эрхийн хугацаа, төлөөлөгч сонгох, дүнг гаргах болон нэг төлөөлөгч хоршооны саналын эрх бүхий хэдэн гишүүнийг төлөөлж байх журмыг бүх гишүүдийн хурал тогтооно. Төлөөлөгчдийн хурлын гишүүдийн тоо нь нийт саналын эрх бүхий гишүүдийн 25 хувиас багагүй хэмжээтэй байна.

45.5. Дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчийг бүх гишүүний хурлаас нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. Төлөөлөгчдийг бүх гишүүдийн хурлаас нэр дэвшүүлнэ. Төлөөлөгч нь бүрэн эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

~~45.6. Төлөөлөгч тус бүрийн саналын эрх нь түүний төлөөлж байгаа хоршооны гишүүдийн саналын эрхийн нийлбэрээр тодорхойлогдоно.~~

45.7. Төлөөлөгч нь тухайн хоршооны гишүүн байна.

46 дугаар зүйл. Хоршооны Тэргүүлэгчид

46.1. Энэ хууль болон хоршооны дүрэмд Тэргүүлэгчгүй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх гишүүний хурлын чөлөөт цагт хоршооны үйл ажиллагааг Тэргүүлэгчид удирдана.

46.2. Хоршооны Тэргүүлэгчид нь дарга, хоёр буюу түүнээс дээш сондгой тоо бүхий гишүүнээс бүрэлдэнэ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч хоршооны Тэргүүлэгчид нь дарга, 7-9 гишүүнээс бүрдэнэ.

46.3. Тэргүүлэгчид нь хоршоог төлөөлөх ба энэ эрхийг хэрэгжүүлэх этгээдэд эрх олгох Тэргүүлэгчдийн олонхын саналаар хэрэгжүүлнэ.

46.4. Тэргүүлэгчид хоёр сар тутам нэгээс доошгүй удаа хуралдана.

46.5. Тэргүүлэгчид нь хоршооны нягтлан бодох бүртгэлийг хуулийн дагуу хөтлүүлж, тайлангийн жилийн дүн гармагц Хяналтын зөвлөлд мэдэгдэн бүх гишүүний хурлаар хэлэлцүүлнэ.

46.6. Жилийн болон завсрын тайлан гаргахад, эсхүл баримжаалсан тооцоогоор алдагдал гарч, түүнийг хоршооны нийт хөрөнгийн дүнгийн 50 хувь болон нөөцийн сангийн хөрөнгөөс нөхөж чадахгүйд хүрвэл Тэргүүлэгчид бүх гишүүний хурлыг нэн даруй зарлан хуралдуулж, уг асуудлыг хэлэлцүүлэх үүрэгтэй.

46.7. Тэргүүлэгчид нь гишүүдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтооно.

46.8. Тэргүүлэгчдийн хурал хуралдуулахтай холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг хоршооны дүрмээр зохицуулна.

47 дугаар зүйл. Тэргүүлэгчдийн хариуцлага

47.1. Тэргүүлэгчид нь энэ хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлэх, хоршооны нууцад хамаарах мэдээллийг чандлан хадгалах үүрэгтэй.

47.2. Тэргүүлэгчид хуульд заасан үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж үзвэл хоршооны гишүүд энэ хуулийн 42.3-т заасны дагуу бүх гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулж, Тэргүүлэгчдийг дахин сонгох, тэдэнд хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх эрхтэй.

47.3. Тэргүүлэгч хууль, дүрэм зөрчиж дараах зөрчил гаргасан тохиолдолд түүнээс учирсан хохирлыг нөхөн төлнө:

47.3.1. хоршооны гишүүдэд оногдох хувь болон орлогоос ашигласан,, захиран зарцуулсан;

47.3.2. хоршооны хөрөнгөөр төлбөр хийсэн;

47.3.3. хоршоог төлбөрийн чадваргүй болгосон буюу дампууруулах нөхцөл бүрдүүлсэн;

47.3.4. хоршооны хөрөнгөөс хууль, дүрэм, журам зөрчиж, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдэд зээл олгож, хөрөнгө оруулалт хийснээс хоршоонд хохирол учруулсан.

47.4. Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр явуулсан үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг Тэргүүлэгчид нөхөн төлөхгүй.

48 дугаар зүйл. Тэргүүлэгчдийн дарга

48.1. Хоршооны дарга нь Тэргүүлэгчдийн дарга байна. Хоршооны дарга Тэргүүлэгчдийн хурлыг даргалах ба Тэргүүлэгчдийн шийдвэрт гарын үсэг зурах бөгөөд хоршооны үйл ажиллагааг зохион байгуулна. Тэргүүлэгчдийн дарга хоршооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах Гүйцэтгэх удирдлагын багийг Тэргүүлэгчдийн хурал, Тэргүүлэгчдийн хуралгүй үед бүх гишүүний хуралд танилцуулснаар томилно.

48.2. Хоршоог төлөөлөх итгэмжлэлд гарын үсэг зурна.

48.3. Тэргүүлэгчдийн санал болгосноор хоршооны Гүйцэтгэх захирлыг томилж, түүнтэй гэрээ байгуулна.

48.4. Дундын хоршооны Тэргүүлэгчдийн даргаар аль нэг гишүүн хоршооны Тэргүүлэгчдийн дарга давхар ажиллахыг хориглоно.

49 дүгээр зүйл. Хяналтын зөвлөл

49.1. Хяналтын зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

49.2. Энэ хуульд зааснаар Тэргүүлэгчид, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгийн хяналтын байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулах үүрэг бүхий Хяналтын зөвлөлийг бүх гишүүний хурлаас байгуулна.

49.3. Энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Хяналтын зөвлөл гурваас доошгүй гишүүнтэй байна.

49.4. Хяналтын зөвлөлийн гишүүдээс дарга, орлогч даргыг сонгоно.

50 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн гишүүн

50.1.Хяналтын зөвлөлийн гишүүд Тэргүүлэгчдийн хуралд зөвлөх эрхтэй оролцоно.

50.2. Хяналтын зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, огцруулах, хоршооны гишүүнээс хасах асуудлыг бүх гишүүдийн хуралдаанд оролцсон гишүүдийн дөрөвний гурвын саналаар шийдвэрлэнэ.

50.3.Хяналтын зөвлөлийн гишүүн нь Тэргүүлэгчээр сонгогдож үл болно.

~~50.4.Хяналтын зөвлөлийн гишүүнээс үндсэн үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гаргасан зардлыг хоршооноос нөхөн өлгөх ба түүнд бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дагуу зохих урамшил олгож болно.~~

51 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн хуралдаан

51.1. Хяналтын зөвлөлийн шийдвэр гаргах хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг дарга, түүний эзгүйд орлогч дарга зарлан хуралдуулна.

51.2. Гишүүдийн олонх нь оролцооноор хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.

51.3. Хуралдааныг зөвхөн дарга, эсхүл түүний орлогч удирдана.

51.4. Хяналтын зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.

51.5. Хоршооны Тэргүүлэгчид, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь Хяналтын зөвлөлийг хуралдуулахыг шаардсан, эсхүл Хяналтын зөвлөлийн дарга шаардлагатай гэж үзсэн бол ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

52 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн бүрэн эрх

52.1. Хяналтын зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

52.1.1.Тэргүүлэгчдийн үйл ажиллагааг хянан шалгах, үүний тулд шаардлагатай баримт бичгийг гаргуулан авах, мэдээлэл, илтгэл сонсох, нягтлан бодох бүртгэл, бусад бичиг баримттай танилцаж, шалгах;

52.1.2. хоршооны жилийн тайлан, цаг үеийн байдлын тухай мэдээ, жилийн орлогын хуваарилалт, алдагдлыг хэрхэн нөхөх зэрэг асуудлаар санал дүгнэлт гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

52.1.3. шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;

52.1.4. хууль тогтоомж болон хоршооны дүрэмд заасан журмын дагуу Тэргүүлэгчид зээл олгох асуудлыг шийдвэрлэх;

52.1.5. зээлийн олголт, эргэн төлөлт, Зээлийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих;

52.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

52.2. Хяналтын зөвлөл шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шинжээчийг төлбөртэй ажиллуулж болно.

53 дугаар зүйл. Хоршооны гүйцэтгэх удирдлага

53.1. Хоршооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах гүйцэтгэх удирдлагад Гүйцэтгэх захирал, санхүү, үйл ажиллагаа хариуцсан захирлуудыг хамааруулна.

53.2. Хоршооны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд нь хоршооны гишүүн бус байна.

54 дүгээр зүйл. Хоршооны гүйцэтгэх удирдлагад тавих шалгуур

54.1. Хоршооны гүйцэтгэх удирдлага дараах шалгуурыг хангасан байна:

54.1.1. дээд боловсролтой эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар дадлага туршлагатай байх ;

54.1.2. бусдад хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

54.1.3. хоршоог удирдах ёс зүйтэй;

54.1.4. ял шийтгэлгүй;

54.1.5. хоршооны удирдлагын сургалтад хамрагдсан байх.

54.2. Дундын хоршооны Гүйцэтгэх захирлаар аль нэг гишүүн хоршооны Гүйцэтгэх захирал давхар ажиллахыг хориглоно.

55 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтан

55.1. Хоршооны бүх гишүүний хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллагын үүрэг гүйцэтгэж, хоршооны албан ёсны шийдвэр гаргах, хоршоог төлөөлж, гэрээ хэлцэл байгуулахад шууд ба шууд бусаар оролцдог Тэргүүлэгчид, Хоршооны дарга, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга болон ерөнхий нягтлан бодогч нарыг хоршооны эрх бүхий албан тушаалтанд тооцно.

55.2. Эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг хоршооны дүрэмд заасан байна.

55.3. Хоршооны эрх бүхий албан тушаалтан нь хоршооны эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос тэргүүнд тавьж, үнэнч шударга, ёс суртахууны хэм хэмжээг сахиж ажиллах үүрэгтэй.

56 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

56.1. Хоршооны эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд сонгогдсон, томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Тэргүүлэгчид өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр 10 хоногийн дотор мэдэгдэнэ.

56.2. Хоршооны эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас хоршоо, гишүүдболон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө:

56.2.1. хоршооны нэр, эд хөрөнгийг хувийн сонирхолдоо ашигласан;

56.2.2. гишүүд, хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгчид санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн;

56.2.3. өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хоршоонд хохирол учруулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХОРШООНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, ХОРШООДЫН МЭРГЭЖЛИЙН БА ХОРШООЛЛЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ

57 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

57.1. Улсын Их Хурал хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

57.1.1. хоршоо үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай орчинг бий болгох, хоршоо хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлох;

57.1.2. Иргэдийг хоршоогоор дамжуулан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөдөлмөрөөрөө хоршиж нийгэм, эдийн засгийн байдлаа сайжруулах нөхцлийг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүү, хөрөнгө оруулалтыг батлах;

57.1.3. хоршооны салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;

57.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

58 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

58.1. Засгийн газар хоршооны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

58.1.1. хоршоог дэмжих хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

58.1.2. хөдөө аж ахуйг эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад байлгаж, тэдгээрийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоог түшиглэн ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр улсын төсөвт тусгасан хөрөнгийн тодорхой хэсгийг хоршоог хөгжүүлэхэд зарцуулах;

58.1.3. хоршооны хөгжлийн чиг хандлагад үндэслэн тухайн жилд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг төлөвлөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

58.1.4. хоршоог дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх;

58.1.5. хоршооны менежментийн үндэс суурийг бий болгох, бэхжүүлэх, менежментийн нөөцийг бүрдүүлэхэд анхаарч боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран менежер, удирдах ажилтан, технологийн нарийн мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

58.1.6. хоршоодын мэргэжлийн болон хоршооллын нэгдсэн холбооны үйл ажиллагааг дэмжиж, хоршооны хөгжлийг дэмжих бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж гаргах, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах ажлыг уг холбоотой хамтран хэрэгжүүлэх;

58.1.7. хоршоо хөгжүүлэх санг байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах журам батлах, сангийн зарцуулалтад хяналт тавих;

58.1.8. Улсын хэмжээнд болон гадаад улсад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулахад голлох үүргийг гүйцэтгэдэг жишиг хоршоог бий болгох, чадавхижуулах эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж дэмжлэг үзүүлэх;

58.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

59 дүгээр зүйл. Хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

59.1. Хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

59.1.1. хоршооны тухай хууль тогтоомж болон хоршоог дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

59.1.2. хоршооны салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлага, бодлогоор хангах;

59.1.3. хоршоог хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийн талаарх саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

59.1.4. хоршооны салбарт мөрдөх нийтлэг стандартыг Хоршооллын нэгдсэн холбоотой хамтран батлах, хэрэгжилтийг хангах ажлыг уг холбоотой хамтран зохион байгуулах;

59.1.5. хоршоогоор дамжуулан жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хоршооны оролцоотой бараа түүхий эдийн биржийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хоршооллын нэгдсэн холбоо болон мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулах;

59.1.6. хоршооны үйл ажиллагаа эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

59.1.7. хоршооны үйл ажиллагаа эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

59.1.8. хоршооны үйл ажиллагаа эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

59.1.9. хоршооны үйл ажиллагааны талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулж, үр дүнг нийтэд мэдээлэх;

59.1.10. хөдөө аж ахуйн жишиг хоршоонд тавих шаардлага, шалгуурыг тогтоох, шинэчилж өөрчлөх

59.1.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

60 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

60.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1. хоршоог орон нутагтаа хөгжүүлэх дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгийг тухайн шатны жил бүрийн төсөвт тусгаж батлах;

60.1.2. хоршоог дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам батлах;

60.1.3. орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын үйл ажиллагааг дэмжих, хоршооны талаар хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион бйгуулах.

61 дүгээр зүйл. Хоршоодын мэргэжлийн холбоо

61.1. Хоршоод үйл ажиллагааныхаа төрөл, чиглэлийн дагуу эвсэн нэгдэж, мэргэжлийн холбоо (цаашид "Мэргэжлийн холбоо" гэх) байгуулж болно. Анхан шатны хоршоо нь аль нэг мэргэжлийн холбооны гишүүн байна.

61.2. Мэргэжлийн холбоо энэ хууль болон Төрийн бус байгууллагын тухай хууль³ тогтоомжийн хүрээнд дүрмээрээ тодорхойлсон зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулж, гишүүн хоршооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, санхүү, менежментийн асуудлаар зөвлөгөө, чиглэл өгөх, зөвлөн туслах, тэдгээрийг нийтлэг удирдлагаар хангах, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

61.3. Мэргэжлийн холбоо нь гишүүнчлэлтэй, гишүүдийн татвараар санхүүждэг төрийн бус байгууллага байна.

61.4. Мэргэжлийн холбооны талаархи энэ хуульд зааснаас бусад асуудал нь Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулагдана.

62 дугаар зүйл. Мэргэжлийн холбооны чиг үүрэг

62.1. Мэргэжлийн холбоо дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ:

62.1.1. гишүүн хоршооныхоо бизнесийн үйл ажиллагаанд харшлахгүй, дарамт шахалт үзүүлэхгүй, зэрэгцэж өрсөлдөхгүйгээр тэдгээрийн үйл ажиллагаанд мэргэжил, боловсрол, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжих, туслах;

62.1.2. хоршооны боловсон хүчнийг сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

62.1.3. нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан тооцоо гаргах ажиллагаанд нь хяналт тавьж, эмх цэгцтэй хөтлөх зааварчилаа өгөх, тайлан тэнцлийн зөв буруу эсэхэд хяналт шалгалт хийж, гарын авлага, заавраар хангах;

62.1.4. гишүүн хоршоодын санхүү, зах зээл, бизнесийн орчны судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангаас мэдээлэл өгөх;

62.1.5. гишүүн хоршоодын бүртгэл хөтөлж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар үнэлэлт өгөх, тодорхойлолт гаргах;

62.1.6. шинээр хоршоо байгуулах, хоршоонд гишүүнээр элсэх хүсэлтэй иргэнийг хоршооны үйл ажиллагаа, удирдлага, менежмент, нягтлан бодох бүртгэлийн талаар анхан шатны сургалтад хамруулж, мэргэшүүлэх, дадлагажуулах, сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээ олгох;

62.1.7. төрөөс хоршооллыг дэмжиж үзүүлж байгаа хөнгөлөлттэй зээл, бусад төслийн эх үүсвэрийг гишүүдэд хүртээмжтэй, шударга хуваарилалт хийхэд төрийн байгууллага, Хоршооллын нэгдсэн холбоотой хамтран ажиллаж, гишүүдийг дэмжих;

62.1.8. гишүүн хоршоодын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тэдгээрийг төлөөлж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

62.1.9 . гишүүн хоршоодын үйл ажиллагааг зохицуулах, үндэсний ба олон улсын хоршоодтой хамтран хөрөнгө оруулттай аж ахуйн нэгж байгуулж, дотоод, гадаадад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тэдгээрийн экспорт, импортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

62.1.10. гишүүн хоршоодын үйл ажиллагаа, санхүүгийн тайланд аудит хийх, баталгаажуулах үүрэг бүхий аудитын байгууллагыг хуулийн дагуу мэргэжлийн бусад холбоод болон хоршооллын нэгдсэн холбоотой хамтран байгуулах;

62.1.11. хөдөө аж ахуйн салбарын хоршоодын мэргэжлийн зөвлөл нь бараа түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлд хоршоог төлөөлж ажиллах;

62.1.12. хуулиар мэргэжлийн холбоонд шилжүүлсэн зарим бүрэн эрх.

63 дугаар зүйл. Хоршооллын нэгдсэн холбоо

63.1. Хоршооллын байгууллагуудын хөгжлийн чиг хандлага, бодлогыг тодорхойлж, хоршоодыг тогтвортой хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилгоор Мэргэжлийн холбоод нэгдэж Хоршооллын нэгдсэн холбоо (цаашид " Нэгдсэн холбоо" гэх) байгуулж болно. Нэгдсэн холбоо нь нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэдэг төрийн бус байгууллага байна.

63.2. Мэргэжлийн холбоо нь нэгдсэн холбооны гишүүн байна.

63.3. Нэгдсэн холбоо дараахь чиглэлээр ажиллана:

63.3.1. хоршооллын салбарын хөгжлийн нэгдсэн бодлого, хоршооллын хөдөлгөөнийг өргөжүүлэх стратегийг тодорхойлоход төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллаж, хоршоологчдын эрх ашгийн хамгаалах;

63.3.2. хоршоо хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх санал боловсруулах;

~~63.3.3. хоршоодын хөгжлийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;~~

63.3.4. төрөөс хоршооллыг дэмжин хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт мэргэжлийн холбоодоор дамжуулан тэдгээрийн гишүүн хоршоог хамруулах, санхүүгийн хөнгөлөлттэй зээл, бусад төслийн эх үүсвэрийг гишүүдэд хүртээмжтэй, шударга хуваарилах чиглэлээр Мэргэжлийн холбоод, төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

63.3.5. хоршооллын давуу тал, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

63.3.6. хоршооны үйл ажиллагааг үнэлж дүгнэх зохистой харьцаа, тэдгээрийн үйл ажиллагаанд тавигдах нэгдсэн стандартыг тогтоох, удирдлага, менежмент, санхүү, бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдүүлэх;

63.3.7. мэргэжлийн холбоодын гишүүн хоршооны удирдлага, боловсон хүчнийг үйлчлэх сургалт, боловсролын байгууллагыг Боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн холбоотой хамтран байгуулах;

63.3.8. хоршоо, тэдгээрийн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аудит хийж, санхүүгийн тайлан тэнцлийг баталгаажуулах үүрэг бүхий мэргэжлийн аудитын байгууллагыг хуульд заасан нөхцлийн дагуу байгуулж, ажиллуулах;

63.3.9. хоршооллын салбарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл өгөх;

63.3.10. хоршооллын салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх стандарт, аргачлалыг тогтоох.

63.4. Мэргэжлийн холбоо нь дараахь эх үүсвэрээс санхүүжинэ:

63.4.1. гишүүн холбоодын татвар;

63.4.2. Засгийн газрын дэмжлэг;

63.4.3. хандяв, зээл, тусламж.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХОРШООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ, ҮЛДЭХ ЭД ХӨРӨНГИЙГ ХУВААРИЛАХ

64 дүгээр зүйл. Хоршоог өөрчлөн байгуулах

64.1. Хоршоог энэ хууль болон Иргэний хуульд заасны дагуу бүх гишүүний хурлын болон шүүхийн шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно. Хоршоог өөрчлөн байгуулах үндэслэл, журмыг Иргэний хуульд заасны дагуу хоршооны дүрмээр тогтооно.

65 дугаар зүйл. Хоршоог бүх гишүүний хурлын шийдвэрээр татан буулгах

65.1. Хоршоог бүх гишүүний хурлын шийдвэрээр дараах тохиолдолд татан буулгаж болно:

65.1.1. гишүүдийн тоо хуульд заасан доод хэмжээнд хүрэхгүй болсон;

65.1.2. хугацаатай байгуулсан хоршооны хугацаа дууссан буюу зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн;

65.1.3. хоршоог татан буулгах тухай бүх гишүүний дөрөвний гурваас доошгүй гишүүн санал гаргасан.

65.2. Хоршоог бүх гишүүний хурлын шийдвэрээр татан буулгах тохиолдолд бүх гишүүний хурлаас татан буулгах комисс томилно. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн дагуу татан буулгах ажиллагааг хийнэ.

66 дугаар зүйл. Хоршоог шүүхийн шийдвэрээр татан буулгах

66.1. Шүүх дор дурдсан үндэслэлээр хоршоог татан буулгана:

66.1.1. Иргэний хуулийн 32.1-д заасан нөхцөл бий болсон;

66.1.2. гишүүдийн тоо хуульд заасан доод хэмжээнд хүрэхгүй болсон ба хоршоо өөрийн санаачлагаар татан буугдаагүй;

66.1.3. хууль, дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан;

66.1.4. хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

66.1.5. хоршооны бүх гишүүдийн хурлыг 3-5 жилд нэг ч удаа зарлан хуралдуулаагүй, санхүүгийн тайлан балансыг гаргаагүй;

66.1.6. хуульд заасан бусад үндэслэл.

67 дугаар зүйл. Хоршоо татан буугдсаныг мэдэгдэх

67.1. Татан буулгах шийдвэр гаргасан этгээд хоршоо татан буугдсан тухай улсын бүртгэлийн байгууллагад гурван хоногийн дотор мэдэгдэнэ.

67.2. Хоршоо татан буугдсаныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд тэмдэглүүлсэн тухай татан буулгах комисс нийтэд мэдээлнэ.

67.3.Хоршооноос авлагатай этгээдэд хоршоо татан буугдсан тухай тусгайлан мэдэгдэнэ.

68 дугаар зүйл. Татан буулгах комисс томилох, эгүүлэн татах

68.1. Татан буулгах тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон татан буулгах комисс татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32.2-т заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

~~68.2. Татан буулгах комиссыг бүх гишүүний хурлаас томилж чадаагүй бол Хяналтын зөвлөл, эсхүл хоршоодын холбооны Тэргүүлэгчид томилж болно.~~

68.3. Татан буулгах комисс байгуулсан байгууллагын шийдвэрээр шаардлагатай гэж үзвэл тухайн комиссыг хугацаанаас нь өмнө татан буулгаж болно.

69 дүгээр зүйл. Татан буулгах комиссыг бүртгэх байгууллагад мэдэгдэх

69.1.Татан буулгах комиссын гишүүдийг бүртгэх байгууллагад мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлнэ.

70 дугаар зүйл. Татан буулгах комисс хоршоог төлөөлж гарын үсэг зурах

70.1.Хоршооны нэрийн хажууд "татан буугдаж байгаа" гэсэн бичилт хийж татан буулгах комиссын гишүүд хоршоог төлөөлж гарын үсгээ зурна.

71 дүгээр зүйл. Хөрөнгө хуваарилахыг хориглох хугацаа

71.1. Хоршооны өр төлбөртэй холбоотой нэхэмжлэлийг Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн барагдуулна.

71.2. Хоршоонд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд ийнхүү нэхэмжлэл гаргах боломжгүй нөхцөлд байгаа бол түүнд төлбөл зохих төлбөрийг нэгэн адил төлнө.

71.3. Төлбөрийн талаар маргаантай бол тухайн этгээдэд ногдох хэсгийг тусгаарласны дараа үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваана.

72 дугаар зүйл. Хоршооны эд хөрөнгийг гишүүдэд хуваарилах

72.1. Хоршооны харилцагчдын нэхэмжлэлийг хангах ажиллагаа дууссаны дараа гишүүдэд хоршооны үлдсэн эд хөрөнгийг хуваарилна.

72.2. Гишүүн нэг бүрт ногдох хувийг нь олгосны дараа хоршооны нийт хөрөнгөөс үлдсэн хэсгийг нийт гишүүдэд тэнцүү хэмжээгээр хуваана. Хоршооны газар, үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсны орлогыг хуваарилах хөрөнгөд оруулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, ХАРИЛЦАГЧДЫН ХАРИУЦЛАГА

73 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн хяналт

73.1. Хоршооны хяналтын зөвлөл /хяналтын зөвлөлгүй бол хянан шалгагч/ хоршооны санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналт, бүртгэл тооцоо, төсвийн зарцуулалт, хөрөнгө хуваарилалт болон гишүүнчлэлийн бүртгэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүртгэлд хяналт хяналт тавьж, бүх гишүүдийн хуралд тайлагнаж байна.

73.2. Хоршооны мэргэжлийн холбоо энэ хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хоршоонд хяналт шалгалт хийнэ.

~~73.3. Хоршоо жил /хурал/ -ын санхүүгийн тайлангаа хоршооны мэргэжлийн холбооны дэргэдэх Аудитын байгууллагаар баталгаажуулж болно.~~

ЗУРГААДУГААР БҮЛЭГ, ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

74 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн хяналт

74.1. Хоршооны хяналтын зөвлөл / хяналтын зөвлөлгүй бол хянан шалгагч/ хоршооны санхүүгийн үйл ажиллагаанд тайлагналт, бүртгэл, тооцоо, төсвийн зарцуулалт, хөрөнгө хуваарилалт болон гишүүнчлэлийн бүртгэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж бүх гишүүний хуралд тайлагнаж байна.

74.2. Хоршооны мэргэжлийн холбоо энэ хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хяналт шалгалт хийнэ.

74.3. Хоршоо жил /хурал/ -ын санхүүгийн тайлангаа хоршооны мэргэжлийн холбооны дэргэдэх Аудитын байгууллагаар баталгаажуулж болно.

75 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

75.1. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

75.2. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

76 дугаар зүйл. Хуулийг дагаж мөрдөх журам

76.1. Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгэгдсэн хоршоог энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жилийн дотор шинэчлэн бүртгэнэ.

Таван үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2008 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хоршооны хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Иргэний хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсгийг нэмсүгэй:

1/ 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг

“33.3. Хоршоог ашгийн төлөө болон ашгийн бус хэлбэрээр байгуулж болно.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “... хоршооны...” гэснийг хассугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйлүүдэд дор дурьдсан агуулгатай дараахь хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/ 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:

"11.3. Хоршоо, хоршооны гишүүдийн хооронд хийгдсэн бараа, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг тодорхойлоход энэ зүйлийн 11.1 дэх заалт хамаарахгүй."

2/ 12 дугаар зүйлийн 12.1.37 дахь заалт:

"12.1.37. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржээр дамжуулан борлуулах бараа, түүхий эдийг стандартад нийцүүлэн бэлтгэх хадгалах, хамгаалах, тээвэрлэхэд зориулж, байнгын бус оролцогчоос гаргасан зардал."

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.15 дахь хэсгийн "төвлөрүүлсэн хөрөнгө" гэсний дараа "хоршооны гишүүнд хуваарилах ногдол орлого" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйлийн хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт:

"18.1.3. Хөдөө аж ахуйн биржийн байнгын бус гишүүн оролцогч хоршооны хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр борлуулсан бараа, түүхий эдийн борлуулалтын орлого, гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучлалын үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого;"

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дараах зүйлд дор дурьдсан агуулгатай дараахь хэсгийг нэмсүгэй:

1/ 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

“7.2. “Хоршооны тухай хуулиар зөвшөөрсөн тохиолдолд хоршоо нь зөвхөн өөрийн гишүүдэд санал болгох хаалттай үнэт цаас гаргаж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн дараах зүйлд дор дурьдсан агуулгатай дараахь заалтыг нэмсүгэй:

1/ 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт:

"18.1.3. Хоршооны тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хоршоо;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын "... компанийг " гэсний дараа " ... хоршоог... " гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын "... компанийг " гэснийг "... компани..." гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай дараахь хэсгийг нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

" 4.3. Хоршооллын нэгдсэн холбоо нь мэргэжлийн холбоо, тэдгээрийн гишүүн хоршоотой хамтран аудитын байгууллага байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд зөвхөн холбооны гишүүн хоршоо, түүний үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд энэ хуулийн дагуу аудит хийнэ."

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар сарын ...ны
өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дараах зүйлд дор дурьдсан агуулгатай дараахь хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/ 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:

"9.4. Хоршоо, хоршооны гишүүн хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртөгийн албан татвар тооцох үнэлгээг энэ хуулийн 9.2-т заасны дагуу татварын албанаас тодорхойлохдоо тэдгээрийн хооронд хийгдсэн гэрээний үнийг баримтална."

2/ 13 дугаар зүйлийн 13.1.23 дахь заалт:

"13.1.28. Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын мал аж ахуйн гаралтай түүхий эдээр хоршооны гишүүний бэлтгэсэн, үйлдвэрлэсэн ноос, ноолууран бүтээгдэхүүн;"

3/ 13 дугаар зүйлийн 13.6.16 дахь заалт:

"13.6.16. хоршооноос гишүүддээ үзүүлсэн түүхий эд, бараа бүтээгдэхүүн зуучлан борлуулах ажил, үйлчилгээ."

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.12 дахь хэсгийн "13.1.20" гэсний дараа "13.6.16" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ